



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН /ДУАГ-ГАБ/2017/03-ГА/



**ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ
ЗЭЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙГДЭЖ БАЙГАА
БОЛОВЧ ХОЛБОГДОХ АРГА ХЭМЖЭЭ АВААГҮЙ БАЙНА.**

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын тухай <ul style="list-style-type: none"> • Аудит хийх үндэслэл, бүрэн эрх • Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт • Аудитын зорилго, хамрах хүрээ • Аудитын хандлага ба арга зүй • Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа • Хүндрэл • Ерөнхий мэдээлэл 	4 4 5 5 6 6
Тэргүүлэх аудитор П.Төвсанаа		
Аудитын менежер Х.Наранцацрал	Бүлэг 1: Дэд зээлийн эргэн төлөлт хэвийн, хугацаандаа төлөгдөж байгаа ч 2016, 2017 онуудад ЖДҮХС-аас санхүүжилт олгоогүй байна.	
Ахлах аудитор Ч.Бэрхсайхан	<i>1.1 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан зөвхөн улсын төсвөөс санхүүжиж байна.</i>	7-8
	<i>1.2 Зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэж байна.</i>	9-10
Аудитор Д.Должинсүрэн	Бүлэг 2: Сонгон шалгаруулалтаар дэмжигдсэн төслийн 20-50 хувийн санхүүжилтийг олгож байна.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утсаар харилцана уу.	<i>2.1 Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан төсөл сонгон шалгаруулсан боловч төслүүд бүрэн хэрэгжиж чадахгүй байна.</i>	10-12
	<i>2.2 Шалгарсан төсөл хэрэгжүүлэгчийг олон нийтэд мэдээлдээгүйгээс гадна ЖДҮХС-ийн хяналт шалгалт зээлийн хэрэгжилтийг хамруулсан байна.</i>	12-13
	Бүлэг 3: Жижиг, дунд үйлдвэрийн сангийн зээлийн зарцуулалт үр дүн багатай байна.	
	<i>3.1 Аудитад хамрагдсан төсөл хэрэгжүүлэгчийн 67.5 хувь нь хэрэгжсэн байна.</i>	14-14
	<i>3.2 ЖДҮХС-аас зээл авсан төсөл хэрэгжүүлэгчийн орлого өссөн боловч татвар төлөлт нэмэгдээгүй байна.</i>	14-15
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 214 тоот	Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал	15
	Дүгнэлт	16
	Зөвлөмж	17
2017 оны 12 дугаар сар	Тайлангийн хавсралтууд	18-22

Т ОВЧИЛСОН ҮГС

УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
МУ	Монгол Улс
ЖДҮХС	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр

Г РАФИК БОЛОН ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ГРАФИК 1	ЖДҮХС-ийн олгосон санхүүжилт, төсөл хэрэгжүүлэгч нараас эргэн төлсөн төвлөрүүлэлтийн судалгаа /2013-2017/
ГРАФИК 2	Төсөл хэрэгжүүлэгч нарын үйл ажиллагааны чиглэл, санхүүжилтийн судалгаа /2013-2016/
ГРАФИК 3	2017 оны байдлаар зээлийн үлдэгдэл /сумдаар/
ГРАФИК 4	Төсөл хэрэгжүүлэгч нарын борлуулалтын орлого /2013-2017/
ХҮСНЭГТ 1	ЖДҮХС-ийн эх үүсвэрийн батлагдсан дүн, олгосон санхүүжилтийн судалгаа
ХҮСНЭГТ 2	Төсөл хэрэгжүүлэгч нарын эргэн төлөлтийн судалгаа /2013-2017/ банкаар
ХҮСНЭГТ 3	Хугацаа хэтрэлттэй төсөл хэрэгжүүлэгч нарын судалгаа
ХҮСНЭГТ 4	ЖДҮХС-д ирсэн төсөл, шалгарсан төсөл, санхүүжилт авсан төслийн судалгаа /2013-2016/
ХҮСНЭГТ 5	ЖДҮХС-аас зээл аваад үйл ажиллагаа явуулаагүй төсөл хэрэгжүүлэгчийн судалгаа


А

УДИТЫН ТУХАЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалгаар Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон орон нутгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт: “Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийн зориулалт, үр дүн”-д аудит хийж, зээлийг үр ашигтай ашигласан эсэх, төслийн зорилго, зорилт биелэгдсэн эсэх, үйл ажиллагаа нь хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаа эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах дэд зорилтын хүрээнд асуудлыг авч үзсэн. Үүнд:



Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт: Дараах хууль эрхийн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур, эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
- Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль;
- МУ-ын аж үйлдвэрийн сайдын 2015.05.18-ны өдрийн 100 дугаар тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”;
- МУ-ын аж үйлдвэрийн сайдын 2016.03.22-ны өдрийн 150 дугаар тушаалаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”;
- Банкны тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль.

Аудитын хамарсан хүрээ:

Хүнс, хөдөө аж ахуйн газар, төсөл сонгон шалгаруулах дэд хорооны төсөл сонгон шалгаруулсан баримт материал, хурлын тэмдэглэл, тооцоо судалгаа, хяналт шалгалтын мэдээ, тайлан, Хаан, Хас, Төрийн банкны 2011-2017 оны зээлийн судалгаа, төсөл хэрэгжүүлэгч байгууллага, иргэдийн төслийн санал, холбогдох баримт материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.

Сайнцагаан сумын 40 төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, холбогдох судалгааны түвшинд аудитад хамруулсан.

Аудитын арга зүй: Аудитад Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим АДБОУС (300), Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг мөрдөж дараах горим сорилыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуйн газрын жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээл хариуцсан мэргэжилтэн Ж.Мөнхбаяртай уулзаж, ярилцлага хийн, холбогдох хууль, журам, төсөл сонгон шалгаруулах дэд хорооны хурлын тэмдэглэл, ажлын баримт, материал, тайлан, мэдээ, судалгааг гаргуулан авч нэгтгэн, дүн шинжилгээ хийсэн.
- Жижиг, дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээл олгодог Хаан, Хас, Төрийн банкнуудаас зээлийн эргэн төлөлт, хүү, алдангийн талаар судалгаа авч нэгтгэн, дүн шинжилгээ хийсэн.
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн Захиргаа хууль эрх зүйн албанаас Хаан, Хас, Төрийн банкт хийсэн гэрээг авч судалсан.
- Сайнцагаан сумын төсөл хэрэгжүүлэгч 40 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон газар дээр очиж, танилцан, н^о ө^о ө^ө ääëëüí ø èí æëëÿú, ööëäí баталгаажуулалт, зэрэгцүүлэлт, харьцуулалт зэрэг аудитын арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас зээлийн зориулалт болон зээл авснаар үйл ажиллагааны борлуулалт, ашиг нэмэгдсэн эсэх, хэдэн ажлын байр нэмэгдсэн талаар судалгаа авч, дүн шинжилгээ хийсэн.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн, хугацаа: Аудитыг тэргүүлэх аудитор П.Төвсанаа хянан удирдаж, аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлын чанарын хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын багийн ахлах аудитор Ч.Бэрхсайхан, аудитор Д.Должинсүрэн нар 2017 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийг дуустал гүйцэтгэлээ.

Аудитын явцад тулгарсан хүндрэл, бэрхшээл

Аудитын явцад банкнуудаас холбогдох судалгаа материал авах үед Банкны тухай хуулийн 7.2 дахь заалт, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, банкнуудын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээнд бусад байгууллагад мэдээлэл өгөх тухай тусгаагүй тул мэдээлэл авах боломжгүй байлаа. Иймээс Хүнс, хөдөө аж ахуйн газраар дамжуулан холбогдох мэдээ, судалгааг авсан тул хугацаа их орж, судалгааг бүрэн гүйцэд авахад хүндрэлтэй байсан.

Иймд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 30.4-т /Тусгай сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана./ гэж заасан учир банкнуудтай байгуулдаг хамтран ажиллах гэрээнд Төрийн аудитын газарт аудит хийхэд шаардлагатай мэдээ, судалгааг саадгүй гаргуулан авах талаар тусгуулах саналтай байна.

Ерөнхий мэдээлэл: УИХ-аас 2007 оны 07 дугаар сарын 27-ны өдөр “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хууль баталсан ба түүнд 2011 оны 2 дугаар сарын 10, 2012 оны 08 дугаар сарын 17, 2015 оны 1 дүгээр сарын 29, 2016 оны 2 дугаар сарын 4-нд тус тус 4 удаагийн нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журмыг хамгийн сүүлд Монгол Улсын аж үйлдвэрийн сайдын 2016 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 48 дугаар тушаалаар баталсан байна.

Дундговь аймгийн хэмжээнд сүүлийн 7 жилийн хугацаанд нийт 95 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 2,747.9 сая төгрөгийн жижиг, дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. 2017 оны 9 сарын байдлаар 59 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 632.8 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. /Хавсралт №1/

Зээл олгогдсон төслийг зориулалтаар авч үзвэл барилгын салбарын төсөл 7.3 хувь, газар тариалангийн төсөл 4.2 хувь, мал аж ахуйн салбарын төсөл 26.3 хувь худалдаа үйлчилгээний төсөл 18.9 хувь, нийт төслийн 43.3 хувь буюу 41 төсөл нь хөнгөн үйлдвэрийн зээл бөгөөд үүний 41 хувь буюу 17 нь хүнсний үйлдвэрийн төсөл шалгарсан байна.

Аймгийн жижиг, дунд үйлдвэрийн хөнгөлөлттэй зээлийг Хаан, Хас, Төрийн банкнуудаар дамжуулан олгож байна. 2016 болон 2017 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан санхүүжилтгүйн улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хөнгөлөлттэй зээл олгоогүй байна.

Бүлэг 1.

Дэд зээлийн эргэн төлөлт хэвийн, хугацаандаа төлөгдөж байгаа ч 2016, 2017 онуудад ЖДҮХС-аас санхүүжилт олгоогүй байна.

1.1 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан зөвхөн улсын төсвөөс санхүүжилт авч байна.

1.1.1 Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд орон нутаг болон улсын төсвөөс санхүүжих боломжтой боловч зөвхөн улсын төсвөөс санхүүжилт авч байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14.3¹-т заасны дагуу жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд улсын төсвөөс хуваарилах хөрөнгийг УИХ, зээл олгох салбар, чиглэл, хугацаа, хүү, эх үүсвэрийн хуваарилалтыг Жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж байна.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн 2013-2017 оны санхүүжилтийг Хөдөлмөрийн яамны сайдын тушаалаар, 2015-2016 оны санхүүжилтийг Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны сайдын тушаалаар тус тус баталжээ. Нийт 4 жилийн санхүүжилт 3,600.0 сая төгрөг батлагдаж, 1,415.5 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. / Хүснэгт 1/

Хүснэгт 1 / мян.төг/

Огноо	Батлагдсан дүн	Олгогдсон санхүүжилт
2013	500,000.0	500,000.0
2014	800,000.0	625,500.0
2015	300,000.0	290,000.0
2016	2,000,000.0	0
Нийт	3,600,000.0	1,415,500.0

2014 онд 29 бизнес эрхлэгчийн төсөл шалгарч, үүнээс 23 төсөлд 625.5 сая төгрөгийн зээл олгож, банкны барьцаа хөрөнгө хүрэлцээгүйн улмаас 2 төсөл, санхүүжилт хүрэлцэхгүй шалтгаанаар 4 төслөөс татгалзсан байна. 2015 онд нэг төсөл хэрэгжүүлэгчийн барьцаа хөрөнгө

хүрэлцээгүйн улмаас 10.0 сая төгрөг буцсан бол 2016 онд яамнаас санхүүжилт олгоогүй тул хуралдах шийдвэр өгөөгүй байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14.4-т / Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд орон нутгийн төсвөөс хөрөнгө олгож болох бөгөөд түүний хэмжээг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж батална./ гэж заасан боловч 2011-2017 онд аймгийн ИТХ-аас жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд орон нутгийн төсвөөс санхүүжилт баталж, олгоогүй байна.

1.1.2 ЖДҮХС-аас Дундговь аймагт 2016, 2017 онд санхүүжилт олгоогүй байна.

¹Жижиг, дунд үйлдвэрлэлийн бодит өсөлт, мөнгөний ханшны өөрчлөлтийг харгалзан тухайн жилд улсын төсвөөс Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд олгох хөрөнгийн хэмжээг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тухайн жилийн төсөвт тусгаж батална.

Монгол Улсын Хөгжлийн банк, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, гүйцэтгэгч банкуудын хооронд байгуулсан гурван талт санхүүжилтийн гэрээнд

График 1

/ сая.төгрөг/



“Үндсэн төлбөрийн эргэн төлөх хуваарь нь гүйцэтгэгч банкнаас жижиг, дунд үйлдвэрийн төслүүдэд олгох зээлийн эргэн төлөлтийн хуваарьтай уялдсан байна.” мөн “Зээлдэгч нь үндсэн төлбөрийг эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлнө.” гэж заасны дагуу дэд зээлдэгчийн эргэн төлөлтийг ЖДҮХС-аас олгосон санхүүжилттэй харьцууллаа.

2013 оноос 2017 оны 3 дугаар улирал хүртэл жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас

зээл олгосон төслүүдийн үндсэн зээлийн эргэн төлөлтөөс 1,905.4 сая төгрөг төвлөрүүлсэн бол 2013 оноос 2015 оны хооронд 1,415.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. График 1-ээс харахад зээлийн хүүг оруулаагүй зөвхөн үндсэн төлөлтөөс орж ирсэн төлбөрөөс 2016, 2017 онд жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжилт олгох бүрэн боломжтой байсан байна.

1.2 Зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэж байна.

1.2.1 Дэд зээлийн эргэн төлөлт хэвийн байна.

Монгол Улсын Хөгжлийн банк, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, гүйцэтгэгч банкуудтай хийсэн гурван талт гэрээний дагуу зээлийн үндсэн төлөлт, хүүгийн төлбөрийг төсөл хэрэгжүүлэгчтэй хийсэн гэрээний дагуу төвлөрүүлж байна.

Дэд зээлийн олголт, зээлийн эргэн төлөлтийн судалгаа /банкаар/
Хүснэгт 2 /мян.төг/

Д/д	Банк	Зээлдэгчийн тоо	Зээлийн дүн /2011 оноос хойш/	2013-2017		
				Төлсөн		
				Зээл	Хүү	Алданги
1	Хаан	36	1,365,500.0	948,734.0	194,640.0	7.0
2	Төрийн	7	190,000.0	177,091.0	25,260.0	6.0
3	Хас	52	1,192,350.0	779,580.0	180,336.0	1,554.0
Дүн		95	2,747,850.0	1,905,404.0	400,237.0	1,567.0

Хүснэгт 2-оос харахад Хас банк нийт төсөл хэрэгжүүлэгчийн 55 хувь буюу 52 төсөл хэрэгжүүлэгчтэй

бөгөөд 2011 оноос хойш 1,192.4 сая төгрөгийн зээл олгож, сүүлийн 5 жилд 779.6

сая төгрөгийн үндсэн төлбөр, 180.3 сая төгрөгийн хүү, 1.5 сая төгрөгийн алданги ногдуулж төвлөрүүлсэн байна.

Төрийн банк 7 төсөл хэрэгжүүлэгчид 190.0 сая төгрөгийн зээл олгож, 177.1 сая төгрөгийн үндсэн төлбөр, 25.3 сая төгрөгийн хүүгийн төлбөр, 0.006 сая төгрөгийн алданги ногдуулж төвлөрүүлэн, одоогийн байдлаар нэг хэвийн зээлдэгчтэй үлджээ.

Хаан банк 36 төсөл хэрэгжүүлэгчид нийт зээлийн хамгийн их буюу 1,365.5 сая төгрөгийг олгож, үндсэн төлбөрөөс 948.7 сая төгрөг, хүүгийн төлбөр 194.6 сая төгрөг, алданги 0.007 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.

1.2.2 Хугацаа хэтрэлттэй зээлдэгч нарын зээлийг шүүхэд шилжүүлэн шийдвэрлэж байна.

Нийт зээлдэгчийн 5 хувь буюу 5 зээлдэгч 2017 оны 3-р улирлын байдлаар 89.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй, зээлийн хугацаа хэтрэлттэй байна. /Хүснэгт 3/ 2011 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан Д.Сувдаагийн хугацаа хэтрэлттэй зээлийг Хас банк ЖДҮХС-д төлж барагдуулсан байна.

Хүснэгт 3

/мян.төг/

№	Төсөл хэрэгжүүлэгч	Зээл авсан огноо	Зээлийн дүн	Зээлийн үлдэгдэл 2017.09.30	Шийдвэрлэсэн байдал	Банк
1	Мандалговийн наран ХХК	9/13/2011	80,000.0	14,377.1	Шүүхэд өгөхөөр бэлдсэн	Хаан
2	Даваа СУВДАА	9/29/2011	40,000.0	8,311.3	Хас банк төлсөн	Хас
3	Мандалговь газ ХХК	3/24/2015	35,000.0	25,954.8	Шүүхийн шийдвэр гарсан	Хаан
4	Говийн тэнгэр ХХК	9/11/2013	35,000.0	24,062.0	Шүүхэд өгсөн	Хас
5	Баяраа БАТБОЛД	11/6/2015	25,000.0	19,827.3	Шүүхийн шийдвэр гарсан	Хас
6	Онгийн хийд ХХК	7/31/2015	10,000.0	5,723.3	Тохиролцсон	Хас
	Нийт дүн		225,000.0	98,255.8		

Гүйцэтгэгч банкнууд төсөл хэрэгжүүлэгч “Мандалговь газ” ХХК, иргэн Б.Батболд нарын хугацаа хэтрэлттэй зээлийн үлдэгдлийг барагдуулахаар шүүхэд хандан, шүүхийн шийдвэр гаргуулсан байна.

Төсөл хэрэгжүүлэгч “Говийн тэнгэр” ХХК, “Мандалговийн наран” ХХК-нуудын өр төлбөрийг барагдуулахаар холбогдох материалыг шүүхэд өгчээ. Харин “Онгийн хийд” ХХК-тай харилцан тохиролцож өр, төлбөрийг шүүхийн шийдвэргүй барагдуулахаар болсон байна.

ЖДҮХС, гүйцэтгэгч банкнуудтай байгуулсан хамтран ажиллах гэрээнд зааснаар зээлийн төлбөрийг дэд зээлдэгчтэй хийсэн эргэн төлөлтийн хуваарийн

дагуу зээлдэгчийн төлсөн эсэхээс үл хамааран улирал бүрийн 10-ны дотор ЖДҮХС-ийн төрийн сан дахь дансанд үл маргах журмаар төвлөрүүлж байна.

Бүлэг 2

Сонгон шалгаруулалтаар дэмжигдсэн төслийн нийт дүнгийн 20-50 хувийн санхүүжилтийг олгож байна.

2.1 Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан төслийг сонгон шалгаруулж, ажлын байр нэмэгдсэн байна.

2.1.1 Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдсан төсөл сонгон шалгаруулсан боловч төслүүд бүрэн хэрэгжиж чадахгүй байна.

Жижиг, дунд үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах дэд комиссыг 2013 оноос 2014 онд Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын захирамжаар 11 хүний бүрэлдэхүүнтэй баталж байсан. 2015 онд журамд өөрчлөлт орж Аж үйлдвэрийн сайдын тушаалаар аймгийн Засаг даргын санал болгосноор 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулахаар шинэчлэгдэн батлагджээ.

Төсөл сонгон шалгаруулах дэд комисст 2013 оноос 2016 оны хооронд 12,294.2 сая төгрөгийн 259 төсөл ирснээс 1,600.0 сая төгрөгийн 67 төслийг шалгаруулж, 1,415.5 сая төгрөгийн 62 төслийг санхүүжүүлсэн байна. /Хүснэгт 4/

Хүснэгт 4

/мян.төг/

№	Он	ЖДҮДС ирсэн төсөл		Шалгарсан төсөл		Санхүүжилтээ авсан	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
1	2013	93	4,900,000.0	16	500,000.0	16	500,000.0
2	2014	84	4,190,200.0	29	800,000.0	23	625,500.0
3	2015	49	1,600,000.0	22	300,000.0	21	265,000.0
4	2016	33	1,604,700.0			2	25,000.0
5	2017						
6		259	12,294,200.0	67.0	1,600,000.0	62.0	1,415,500.0

Дундговь аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөнд тусгагдсан “Хөнгөн болон хүнсний үйлдвэрийг аймаг, сумдын мал, малын гаралтай түүхий эдийг түшиглэн байгуулна.” гэсэн зорилтын дагуу мал аж ахуйтай холбоотой мал үржүүлэх, мах, сүү, цагаан идээ боловсруулах, хадгалах 16 төсөлд 404.5 сая төгрөг, хөнгөн үйлдвэрийн 18 төсөлд 330.0 сая төгрөг шалгаруулсан нь нийт төслийн 55 хувийг эзэлж байна.

График 2

/мян. төг/



Мөн хүнсний үйлдвэрийн талх нарийн боов, хоолны газрын 255.0 сая төгрөгийн 11 төслийг дэмжжээ.

Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөний хөтөлбөр 2.2.2-т “Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, орон нутаг болон хөрш зэргэлдээ зах зээлд нийлүүлнэ.”, мөн “Чулуу бутлах, ангилах болон бетон зуурмагийн үйлдвэр байгуулах, барилгын бетон хийц үйлдвэрлэх цех байгуулах” гэж тусгасны дагуу 4 төсөлд 126.0 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Сонгогдсон төслүүд аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдаж байгаа боловч дэмжигдсэн зарим төслийн нийт мөнгөн дүнгийн 20-50 хувийг санхүүжүүлсэн байна. Тус төслүүд хэрэгжих боломжгүй, тооцооллын хувьд үндэслэлгүй, зээлдэгч төлөвлөсөн хэмжээндээ үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байгаа нь аудитын явцад ажиглагдлаа. Иймд аймгийн хэмжээнд ЖДҮ-ийн талаар баримтлах бодлого гаргаж, бодлогын дагуу хөнгөлттэй зээлийг олгож байх шаардлагатай байна.

2.1.2 Хөнгөлөлттэй зээлд хамрагдсан төслүүд ажлын байр нэмэгдүүлсэн ч 30 хувь нь түр ажлын байр байна.

Аудитаар ЖДҮХС-ийн зээлийн үлдэгдэлтэй Сайнцагаан сумын 40 төслийг сонгон, төслийн хэрэгжилтийг шалгах үед:

- 23 төсөл хэрэгжсэн;
- 4 төсөл төсөвтөө багтаан үйл ажиллагаагаа өөрчилж хэрэгжсэн;
- 13 төсөл хэрэгжээгүй /үүний 5 төсөл хугацаа хэтрэлттэй, Шүүхэд шилжүүлсэн/ байна.

Төсөл нь хэрэгжиж байгаа 23 иргэн, ААНБ-аас ЖДҮХС-ийн зээлд хамрагдсанаар үйл ажиллагаанд ямар өөрчлөлт гарсан талаар судалгаа авсан.

Судалгаанд 8 ААНБ, 15 иргэн хамрагдсан бөгөөд нийт төсөл хэрэгжүүлэгч нарын хадгалагдсан ажлын байр 35, шинээр 31 ажлын байр нэмэгджээ. Үүнээс улирлын чанартай үйл ажиллагаа явуулдаг иргэн, ААНБ-ын 20 ажлын байр буюу 30 хувь нь түр ажлын байр байна.

Судалгаанд хамрагдсан 7 аж ахуйн нэгжийн борлуулалтын орлого зээл авснаас хойш тодорхой хэмжээгээр нэмэгдсэн нь татварын тайлангаар харагдаж байлаа. Харин иргэдийн хувьд орлого нэмэгдсэн гэж байгаа боловч нотлох баримт хангалтгүй, татварт сар бүр тогтмол татвар төлж байна.

2.2 Шалгарсан төсөл хэрэгжүүлэгчийг олон нийтэд мэдээлдэггүйгээс гадна ЖДҮХС-ын хяналт шалгалт зээлийн хэрэгжилтийг хамруулсан байна.

2.2.1 Төсөл хүлээн авах болон амжилттай хэрэгжиж байгаа төслийн талаар иргэдэд мэдээлж ажилласан байна.

Аж үйлдвэрийн сайдын шийдвэрээр жижиг, дунд үйлдвэрийн төсөл хүлээн авах хугацааг товлож, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэх үүргийг Жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн хариуцаж, аймгийн Цоглог телевиз болон Хөдөлмөр халамж, үйлчилгээний газар /хуучнаар Хөдөлмөрийн хэлтэс/, Хүнс, хөдөө аж ахуйн газрын албан сайт болон Facebook хуудсаар дамжуулан иргэдэд зар мэдээг хүргэж ажилласан байна. /Хүснэгт 4/

Төсөл сонгон шалгаруулах дэд хорооны үйл ажиллагааны талаар мэдээллийг ерөнхий байдлаар танилцуулж байгаа боловч ямар төслүүд ямар шалгуурын дагуу сонгогдож, ямар чиглэлийн төслүүд хэрэгжих гэж байгаа талаар олон нийтэд мэдээлэл хүрэхгүй байна.

Амжилттай хэрэгжиж байгаа төслүүдийг жил бүр зохион байгуулагддаг “Дундговь түншлэл” үзэсгэлэн худалдаанд оролцуулж ард иргэдэд танилцуулсан байна. Мөн Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас 2013 онд зээл авсан “Агь” мужааны цех, “Саруул сүмбэр” ХХК, “Амар” тахианы аж ахуйг МАСС агентлагийн “Баялаг бүтээгчид” нэвтрүүлэгт оролцуулан олон нийтэд сурталчилж ажилласан байна. /хавсралт №1, №2, №3/

Төсөл хүлээн авах, амжилттай хэрэгжиж байгаа төслүүдийг олон нийтэд мэдээлж, сурталчилах ажил хангалттай хийгдэж байгаа боловч, төсөл сонгон шалгаруулах үйл ажиллагаа болон шалгарсан төслүүдийг ил тод мэдээлэлж, сурталчилах ажил хангалтгүй байгаа тул анхаарч ажиллахыг төсөл сонгон шалгаруулах дэд комисст зөвлөмжөөр хүргүүлээ.

2.2.2 ЖДҮХС-ийн шалгалт зөвхөн зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн төслийн хэрэгжилтийг хамарсан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас /хуучнаар Аж үйлдвэрийн яам/ Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 11.1.1 /жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомж болон жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг зохион байгуулах, хяналт тавих/, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журмын 5.4 /Зээлийг дамжуулан олгож буй банкны гэрээний биелэлт, дэд хорооны үйл ажиллагаа, хөнгөлөлттэй зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүргийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан дангаар болон Аж үйлдвэрийн яамтай хамтарсан ажлын хэсэг гүйцэтгэнэ/ гэж заасны дагуу 2012 - 2014 онуудад ЖДҮХС-аас зээл авсан

иргэдийн үйл ажиллагаанд 2015 онд, 2014 - 2015 онуудад зээл авсан иргэдийн үйл ажиллагаанд 2017 онд хоёр удаа хяналт, шалгалт хийсэн байна.

Яамны шалгалтаар зөвхөн зээл авсан иргэд, ААНБ-ын үйл ажиллагаатай танилцаж, үнэлэлт дүгнэлт өгч, 2017 онд “ХӨҮМЛАНД” ХХК, “Говийн тэнгэр” ХХК-нуудад зээлээ буцаан төвлөрүүлэх мэдэгдэл хүргүүлжээ. Гэвч дээрх шалгалтын дагуу одоогоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2016 онд төлөөлөгч Р.Мөнхтогтохоор ахлуулсан ажлын хэсэг 2015 онд олгогдсон зээлийн хэрэгжилтийг шалгасан байна. Уг шалгалтаар аймгийн Засаг дарга болон холбогдох хүмүүст анхаарч ажиллах чиглэл хүргүүлжээ.

Мөн 2017 онд аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс ЖДҮХС-ийн үлдэгдэлтэй байгаа зээлдэгч нарын үйл ажиллагааг шалгасан боловч эцсийн байдлаар шалгалтын тайлан, мэдээ, авах арга хэмжээ гараагүй байлаа.

ЖДҮХС-д хяналт шалгалтууд хууль, журмын дагуу хийгдэж байгаа боловч, зөвхөн зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн төслийн хэрэгжилтийг шалгаж, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зохион байгуулсан ажил байхгүй байгаагаас үр дүн гараагүй байна.

Иймд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, аймгийн ИТХ-ын шалгалт болон аудитын шалгалтуудаар тогтоогдсон төсөл хэрэгжүүлж, үйл ажиллагаа явуулаагүй, зээлийг зориулалт бусаар ашигласан дараах 8 иргэн, аж ахуйн нэгжийн зээлийн үлдэгдлийг ЖДҮХС-д төвлөрүүлж, зээлийн хүүг арилжааны банкны хүүрүү шилжүүлэх саналыг ЖДҮХС-д зөвлөмжөөр хүргүүлж байна. /Хүснэгт5/

ЖДҮХС-аас зээл авч үйл ажиллагаа явуулаагүй иргэд, ААНБ-ын судалгаа
Хүснэгт 5 /мян. төг/

№	Зээл дэгчийн төрөл	Зээлдэгчийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Зээл авсан огноо	Анх авсан зээл	Зээл үлдэгдэл /2017.09.30/	Банк
1	ХХК	Алтан цант ХХК	Махны агуулах, нөөцлөх	2013.08.06	35,000.0	8,883.5	Хаан
2	ХХК	Зотол хаан Трейд ХХК	Цэвэр ус	2013.08.30	25,000.0	9,999.8	Хас
3	Иргэн	Цэнд-Аюуш Энхцэцэг	Талх нарийн боов	2014.10.27	20,000.0	10,832.9	Хас
4	Иргэн	Жамъян МӨНХБААТАР	Хэвлэл	2014.12.31	21,000.0	3,427.4	Хас
5	ХХК	ᠪᠠᠲᠠᠭ ᠣᠶᠤᠨᠪᠢᠯᠢᠭ	Махны чиглэлийн үхрийн ферм	2015.01.24	38,500.0	24,023.6	Хаан
6	Иргэн	Батаа ОЮУНБИЛЭГ	Оёдлын үйлдвэрлэл	2015.07.30	10,000.0	5,624.7	Хас

7	Иргэн	Дамиранжав БАДРАХ	Цэвэр ус	2015.07.30	20,000.0	10,960.4	Хас
8	Иргэн	Цэдэнбат ЭНХТУЯА	Талх нарийн боов	2015.08.12	10,000.0	5,806.0	Хас
					179,500.0	79,558.2	

Бүлэг 3.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн зарцуулалт үр дүн багатай байна.

3.1. Аудитад хамрагдсан төсөл хэрэгжүүлэгчийн 67.5 хувь нь хэрэгжсэн байна.

Дундговь аймгийн хэмжээнд 2017 оны 3 улирлын байдлаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 632.8 сая төгрөгийн зээлтэй нийт 59 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байна. Уг зээлдэгч нарыг сумдаар нь авч үзвэл хамгийн их буюу 84.7 хувийг Сайнцагаан сум, 3.4 хувийг Говь-Угтаал, Дэлгэрхангай, Сайхан-Овоо сум, 1.7 хувийг Адаацаг, Хулд, Эрдэнэдалай сумд эзэлж байна.

График 3

/ хувь/



Аудитад ЖДҮХС-аас төсөл хэрэгжүүлэгч нарын 68 хувь буюу Сайнцагаан сумын 40 төсөл хэрэгжүүлэгчийг хамрууллаа. Үүний 67.5 хувь буюу 27 төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Төсөл хэрэгжээгүй, үйл ажиллагаа явуулаагүй 13 төслийн 5 нь хугацаа хэтрэлттэй, шүүхээр шийдвэрлэгдэж байна.


Хэрэгжээгүй 13 төсөл бүгд шинээр

үйл ажиллагаагаа эхлэх төслүүд байсан байна. Иймд төсөл сонгон шалгаруулах комисс шинээр эхлэх төслүүдийн санхүүжилтийг сайн судалж, төсөл хэрэгжиж хүрэлцэхүйц хэмжээний санхүүжилтийг олгоход анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.2 ЖДҮС-аас зээл авсан төсөл хэрэгжүүлэгчийн орлого өссөн боловч татвар төлөлт нэмэгдээгүй байна.

Аудитаар төсөл хэрэгжүүлж байгаа зээлдэгч нараас зээлийн зарцуулалт, борлуулалтын орлого, НДШ болон татвар төлөлтийн талаар судалгаа авсан.

Судалгаанд хамрагдсан нийт төсөл хэрэгжүүлэгчид зээлийн 45 хувийг эргэлтийн хөрөнгө, 42 хувийг тоног төхөөрөмж, 9 хувийг барилгад үлдсэн 4 хувийг урсгал засварт зарцуулсан байна.



Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд төсөл хэрэгжүүлж эхэлснээр борлуулалтын орлого нэмэгдсэн боловч орлогын албан татварыг төлдөггүй байна. /График 4/

Судалгаанд хамрагдсан иргэд, ААНБ-ын 81 хувь нь албан татвар төлдөг, 6 хувь чөлөөлөгддөг, 13 хувь нь огт татвар

төлдөггүй байна. Татвар төлдөг 19 төсөл хэрэгжүүлэгчээс 7 ААНБ ашгаасаа хамаарч орлогын албан татвар төлдөг бол үлдсэн 12 нь сар болгон тогтмол татвар төлж байна.

Төсөл эхлэхээс өмнө хадгалагдсан ажлын байр 35, шинээр 31 ажлын байр нэмэгдсэнээс 11 зээлдэгчийн 19 ажлын байранд НДШ тогтмол төлдөг, 24 ажлын байранд НДШ төлдөггүй, 12 зээлдэгчийн 23 ажлын байранд НДШ огт төлдөггүй байна.

Дээрх судалгаанаас харахад ЖДҮХС-аас зээл авсан иргэн, ААНБ-ын тоног төхөөрөмж, эргэлтийн хөрөнгө сайжирч борлуулалт нэмэгдэж байгаа боловч орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн орлогууд нэмэгдэхгүй байна.

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

“Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлийн зориулалт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаас Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 30.4-т /Тусгай сангийн зарцуулалтын тайланд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийж, дүгнэлт гаргана./ гэж заасан учир банкнуудтай байгуулдаг хамтран ажиллах гэрээнд Төрийн аудитын газарт аудит хийхэд шаардлагатай мэдээ, судалгааг саадгүй гаргуулан авах талаар тусгуулах саналтай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг орон нутаг болон улсын төсвөөс санхүүжүүлэх боломжтой, гэвч зөвхөн улсын төсвөөс санхүүжиж байна. 2016 он, 2017 онуудад улсын төсөвт хөрөнгө мөнгө байхгүйгээс санхүүжилт олгоогүй байна.
2. ЖДҮХС, Гүйцэтгэгч банкнуудтай байгуулсан хамтран ажиллах гэрээнд зааснаар зээлийн эргэн төлөлтийг дэд зээлдэгчтэй хийсэн эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлдэгчийн төлсөн эсэхээс үл хамааран улирал бүрийн 10-ны дотор ЖДҮХС-ийн төрийн сан дахь дансанд үл маргах журмаар төвлөрүүлж байна.
3. Сонгогдсон төслүүд аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдаж байгаа боловч дэмжигдсэн зарим төслийн нийт мөнгөн дүнгийн 20-50 хувийг олгосон нь тус төслүүд хэрэгжих боломжгүй санхүүгийн хувьд үндэслэлгүй, зээлдэгч төлөвлөсөн хэмжээндээ үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байна.
4. ЖДҮХС-ийн шалгалт зөвхөн зээл авсан иргэн, аж ахуйн нэгжийн төслийн хэрэгжилтийг хамарсан байна.
5. Аудитад хамрагдсан төсөл хэрэгжүүлэгчийн 67.5 хувь нь хэрэгжсэн байна.
6. ЖДҮХС-аас зээл авсан төсөл хэрэгжүүлэгчийн борлуулалтын орлого өссөн боловч татвар төлөлт нэмэгдээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн холбогдох албан тушаалтанд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Төсөл сонгон шалгаруулах дэд комисст:

1. Аймгийн хэмжээнд ЖДҮ-ийн талаар баримтлах бодлого гаргаж, бодлогын дагуу хөнгөлөлттэй зээлийг олгож байх.
2. Шинээр хэрэгжүүлж эхлэх төслийг шалгаруулахдаа санхүүгийн тооцооллыг үндэслэлтэй хийсэн эсэхийг шалгаж, хөнгөлөлттэй зээлийг хэрэгжих хэмжээнд санхүүжилтийг олгох.
3. Хяналт, шалгалтын мөрөөр зохих арга хэмжээг авч, төслийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах.
4. Төсөл сонгон шалгаруулах комиссын үйл ажиллагааг олон нийтэд ил тод нээлттэй сурталчилж байх.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд:

1. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журмын 5.6, 2016 оны Хамтран ажиллах гэрээний 4.16-д /Энэхүү гэрээний 2.5.7-д заасны дагуу Зээлдэгч тодорхой зорилго бүхий төсөлд зориулсан хөрөнгийг зориулалт бусаар ашигласан нь хяналт шалгалтаар тогтоогдвол тухайн зээлдэгчид олгогдсон эх үүсвэрийг ЖДҮХС-д шилжүүлсэн тохиолдолд тухайн зээлийг өөрийн банкны энгийн нөхцөлтэй зээлд шилжүүлэх эрхтэй/ гэж заасны дагуу зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй 8 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дээрх арга хэмжээ авах. /Хүснэгт 5/

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Ч.БЭРХСАЙХАН

АУДИТОР

Д.ДОЛЖИНСҮРЭН

ХЯНАСАН :

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.НАРАНЦАЦРАЛ

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ ТАЙЛБАР

Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-т заасны дагуу аудитын тайлангийн төслийг аймгийн Төсөл сонгон шалгаруулах дэд хороонд танилцуулж, санал тайлбарыг авлаа.

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг
Утас/Факс: 70-59-25-86


2017.12.18 № 01/320
танай _____ -ны № _____ -т




ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн Аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Санал, тайлбар байхгүй.

ДАРГА  Б.МӨНХЖАРГАЛ



120333360

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/30

Мандалговь

Г Гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.2, 2.4, Гүйцэтгэлийн аудитын журмын 12 дугаар зүйлийн 12.40, Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журмын 4.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ДУАГ-ГАБ/2017/03-ГА/-г баталсугай.
2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (зөвлөмж)-ыг хавсралтаар баталсугай.
3. “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Үндэсний аудитын газар, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Төсөл сонгон шалгаруулах дэд хороо болон аймгийн ИТХ тус тус хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2018 оны 3 дугаар сарын 10-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Төсөл сонгон шалгаруулах дэд хорооны дарга /О.Бат-Эрдэнэ/-т зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2018 оны 1 дүгээр улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, гүйцэтгэлийн аудитын багийн аудитор /Д.Должинсүрэн/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ТӨВСАНАА



D:\office\Гушаал\A4\JDU report batalgajuulah tuhai.docx

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТУУД

2011 оноос 2015 онд ЖДҮХС-аас зээл авсан иргэд, ААНБ-ын судалгаа

Хавсралт № 1

№	Зээлдэгчийн нэр	Сум	Үйл ажиллагааны чиглэл	Банк	Зээл олгосон огноо	Олгос он зээл	Тайлбар
1	2	3	4	5	6	7	8
1	Б. Дэмбэрэлням	Сайнцагаан	ХАА	Төрийн	9/2/2011	13.0	Хаагдсан
2	Технож	Сайнцагаан	Үйлчилгээ	Төрийн	11/1/2011	70.0	Хаагдсан
3	ОРГО БАТАА	Сайнцагаан	Явуулын халуун ус	ХААН	7/7/2011	25.0	Хаагдсан
4	БАЛДАН ТҮВШИНЦОГ	Сайнцагаан	Цайны газар зочид буудал	ХААН	7/9/2011	25.0	Хаагдсан
5	ЖАСРАЙ ОДОНПҮРЭВ	Дэрэн сум	Цагаан идээ	ХААН	7/22/2011	12.0	Хаагдсан
6	ЭНХБАТ СҮРЭНЦЭЦЭГ	Сайнцагаан	Захиалгат хоол	ХААН	8/19/2011	60.0	Хаагдсан
7	ХИШИГ-ӨГӨӨМӨР ХХК	Сайнцагаан	Зоогийн газар	ХААН	8/20/2011	65.0	Хаагдсан
8	АЛТАТЦАГААН ТОЛГОЙ ХХК	Сайнцагаан	Гар урлал	ХААН	9/7/2011	25.0	Хаагдсан
9	ЗОТОЛ МАНДАЛ ХХК	Сайнцагаан	Эко амралтын хүрээлэн	ХААН	9/13/2011	80.0	Хаагдсан
10	МАНДАЛГОВИЙН НАРАН ХХК	Сайнцагаан	Шингэрүүлсэн хийгээр үйлчлэх төв	ХААН	9/13/2011	80.0	Шүүх
11	ТАЛЫН ГУРВАН УУЛ ХХК	Сайнцагаан	Тэжээлийн цех	ХААН	9/14/2011	65.0	Хаагдсан
12	БМБХ ХХК	Сайнцагаан	Зочид буудал зоогийн газар	ХААН	9/15/2011	100.0	Хаагдсан
13	АРИУНБОЛОР ХХК	Сайнцагаан	Nitro restaurant nignt club and karaoke	ХААН	9/20/2011	100.0	Хаагдсан
14	ТҮМЭНӨНДӨР ХХК	Сайнцагаан сум	Тоосго, блокны үйлдвэр	ХААН	9/26/2011	36.0	Хаагдсан
15	БААТАР ХИШИГБАТ	Адаацаг сум	Үнээний ферм	ХААН	9/2/2011	10.0	Хаагдсан
16	АМГАЛАНБААТАР ГАРМАА	Сайхан-овоо	Хувцас захиалга засвар	ХААН	9/19/2011	10.0	Хаагдсан
17	МАНДАЛГОВЬ ХҮНС ХХК	Сайнцагаан	Чихэр, чацарганы жүүс үйлдвэрлэх	ХААН	9/15/2011	80.0	Хаагдсан
18	ОНГИ-ЭЭЖ ХХК	Сайнцагаан	Чацарганы тариалалт, боловсруулалт хийх	ХААН	10/3/2011	80.0	Хаагдсан
19	ЖАНЦАН НАРАНГЭРЭЛ	Дэлгэрхангай	Сүү сүүн бүтээгдэхүүн	ХААН	10/19/2011	8.0	Хаагдсан
20	Тогтох Мандал ХХК	Сайнцагаан	Түрээсийн үйлчилгээ	Хас	7/26/2011	50.0	Хаагдсан
21	Их Говийн Шим ХХК	Сайнцагаан	Мах нөөцлөх	Хас	8/31/2011	50.0	Хаагдсан
22	Отгонсүрэн ЭНХБАТ	Сайнцагаан	Талх нарийн боов	Хас	9/20/2011	14.0	Хаагдсан
23	Цэвэгжав МАНДАХНАР	Сайнцагаан	Туслах аж ахуй	Хас	9/20/2011	10.0	Хаагдсан
24	Өлзийбаатар АНХБАЯР	Сайнцагаан	Сийлбэр бэлэг дурсгал	Хас	9/20/2011	4.5	Хаагдсан
25	Дамбадаржаа ЛХАГВАДОРЖ	Сайнцагаан	Үнээний ферм	Хас	9/20/2011	9.8	Хаагдсан
26	Гочоо ЦОГОО	Сайнцагаан	Үнээний ферм	Хас	9/27/2011	27.0	Хаагдсан
27	Чулуун-Эрдэнэ СЭРГЭЛЭНБААТ АР	Сайнцагаан	Тавилгын үйлдвэрлэл	Хас	9/28/2011	26.0	Хаагдсан
28	Даваа СУВДАА	Сайнцагаан	Оёдол	Хас	9/29/2011	40.0	Хаагдсан
29	Гүндсамба АМАРСҮРЭН	Сайнцагаан	Хүүхдийн тоглоомын үйлчилгээ	Хас	9/29/2011	14.5	Хаагдсан
30	Батсайхан ДАШГАРАВ	Сайнцагаан	авто засвар	Хас	10/7/2011	9.3	Хаагдсан

31	Дамбий ЖАРГАЛСАЙХАН	Сайнцагаан	Гутал зан засвар	Хас	10/7/2011	3.3	Хаагдсан
32	Саадагын Овоо ХХК	Сайнцагаан	Барилга	Хас	10/28/2011	50.0	Хаагдсан
33	Элбэг Хайрхан ХХК	Сайнцагаан	Тоосгоны үйлдвэр	Хас	1/6/2012	80.0	Хаагдсан
34	Мандалшилтгээн ХХК	Сайнцагаан	Бетонон эдлэл үйлдвэрлэл	ХААН	8/14/2013	40.0	Үлдэгдэлтэй
35	Буянтогтох Ганхуяг	Сайнцагаан	Тахианы аж ахуй	ХААН	9/19/2013	35.0	Үлдэгдэлтэй
36	Саруул сүмбэр ХХК	Сайнцагаан	Хагас боловсруулсан бүтээгдэхүүн	Хас	10/8/2013	35.0	Хаагдсан
37	Логийн говь ХХК	Сайнцагаан	авто засвар	Хас	8/30/2013	25.0	Үлдэгдэлтэй
38	Алтан цант ХХК	Сайнцагаан	Махны агуулах, нөөцлөх	ХААН	8/6/2013	35.0	Үлдэгдэлтэй
39	Говийн тэнгэр ХХК	Сайнцагаан	Зочид буудал зоогийн газар	Хас	9/11/2013	35.0	Шүүх
40	Өндөр ханги ХХК	Дэлгэрхангай	Ямааны фермер	Хас	8/12/2013	35.0	Үлдэгдэлтэй
41	Сартус ХХК	Сайнцагаан	авто засвар	ХААН	10/17/2013	25.0	Үлдэгдэлтэй
42	Зотол хаан Трейд ХХК	Сайнцагаан	Цэвэр ус	Хас	8/20/2013	25.0	Үлдэгдэлтэй
43	Дэлгэрэх Бүрд ХХК	Сайнцагаан	Зочид буудал зоогийн газар, авто угаалга	ХААН	9/2/2013	35.0	Хаагдсан
44	Амар мандал ХХК	Сайнцагаан	Аялал жуулчлал	ХААН	8/13/2013	35.0	Үлдэгдэлтэй
45	Буянт Чандмань ХХК	Сайнцагаан	Барилгын төмөр дээвэр үйлдвэрлэх	ХАС	11/13/2013	30.0	Үлдэгдэлтэй
46	Шарбанди Бөндөгхорол	Эрдэнэдалай	Сүлжмэл болон ноосон бүтээгдэхүүн	ХААН	10/18/2013	25.0	Үлдэгдэлтэй
47	ЮУССАРИТУ ХХК	Сайнцагаан	Барилгын материал үйлдвэрлэл	Төрийн	11/20/2013	35.0	Үлдэгдэлтэй
48	Пэлжээ Одончимэг	Сайнцагаан	Сүлжмэл болон ноосон бүтээгдэхүүн	Хас	9/2/2013	25.0	Үлдэгдэлтэй
49	Адъяа Энхбаатар	Сайнцагаан	Тавилгын үйлдвэрлэл	Төрийн	8/23/2013	25.0	Хаагдсан
50	Донидагва Бат-Эрдэнэ	Сайнцагаан	Авто угаалга, засвар, цайны газар	Хас	9/22/2014	30.0	Үлдэгдэлтэй
51	Юндэн Отгондэлгэр	Сайнцагаан	Мах бэлтгэх үйлдвэр байгуулах	Хас	9/19/2014	29.0	Үлдэгдэлтэй
52	Тогтохмандал ХХК	Сайнцагаан	Мах боловсруулах үйлдвэр	Хас	10/2/2014	25.0	Хаагдсан
53	Баасанжав Өлзиймягмар	Сайнцагаан	Малын дайвар бүтээгдэхүүн боловсруулах	Хас	10/3/2014	15.0	Үлдэгдэлтэй
54	Чойнхор Алтанцэцэг	Сайнцагаан	Хагас боловсруулсан бүтээгдэхүүн	Хас	10/31/2014	30.0	Үлдэгдэлтэй
55	Эд Оч ХХК	Сайнцагаан	Гутал зан засвар	Хас	10/7/2014	13.0	Үлдэгдэлтэй
56	Ганбат Нарангарав	Сайнцагаан	Good Chicken түргэн хоол	Хаан	10/16/2014	15.0	Үлдэгдэлтэй
57	Сандаг Отгонпүрэв	Сайнцагаан	Үсчин	Хас	10/8/2014	20.0	Үлдэгдэлтэй
58	Цогоо НАРАНДЭЛГЭР	Сайнцагаан	Үнээний ферм	Хаан	10/27/2014	30.0	Үлдэгдэлтэй
59	Цэнд-Аюуш Энхцэцэг	Сайнцагаан	Талх нарийн боов	Хас	10/27/2014	20.0	Үлдэгдэлтэй
60	Батбаяр Тунгалаг	Сайнцагаан	Үсчин, гоо сайхан	Хас	10/27/2014	30.0	Үлдэгдэлтэй
61	Ачлал Оргил ХХК	Сайнцагаан	Саамны сувилал	Хас	10/27/2014	30.0	Үлдэгдэлтэй
62	Н.ЭРДЭНЭБАТ-Говийн гэгээ ХХК	Сайнцагаан	Талх нарийн боов	Хаан	10/28/2014	15.0	Үлдэгдэлтэй
63	Ариунболор ХХК	Сайнцагаан	Зочид буудал	Хас	11/7/2014	40.0	Үлдэгдэлтэй
64	ШУВУУХАЙ ХАЙРХАН ХОРШОО	Хулд	Эсгий	Хаан	11/7/2014	16.0	Үлдэгдэлтэй
65	Ичинхорол ШИНЭХҮҮ	Сайнцагаан	Саамны сувилал	Хаан	11/10/2014	30.0	Үлдэгдэлтэй
66	Цэвээндорж Цогсүрэн	Сайнцагаан	Авто засвар, порсунк тохируулгын үйлчилгээ	Хас	11/6/2014	30.0	Үлдэгдэлтэй

67	Цэмбэ Ганхуяг	Сайнцагаан	Алт мөнгөний дархан	Хас	12/7/2014	10.0	Үлдэгдэлтэй
68	Осор Цолмонбаатар	Эрдэнэдалай	Үнээний ферм	Төрийн банк	11/6/2014	25.0	Хаагдсан
69	Буянтогтох Уртнасан	Говь-Угтаал	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Төрийн	11/11/2014	10.0	Үлдэгдэлтэй
70	Лхам Дамбадүгэр	Говь-Угтаал	Тахианы аж ахуй	Төрийн	11/11/2014	12.0	Үлдэгдэлтэй
71	Мандал Шилтгээн	Сайнцагаан	Барилгын материал үйлдвэрлэл	Хас	12/30/2014	21.0	Үлдэгдэлтэй
72	Жамъян МӨНХБААТАР	Сайнцагаан	Хэвлэл	Хас	12/31/2014	21.0	Үлдэгдэлтэй
73	МАНДАЛГОВЬ ГАЗ	Сайнцагаан	Авто машин хийгээр цэнэглэх станц	Хаан	2015/03/24	35.0	Шүүх
74	ХОНИНЫ ХИШИГ	Дэлгэрхангай	гипс үйлдвэрлэх	Хаан	2015/02/05	35.0	Үлдэгдэлтэй
75	ХӨУМЛАНД	Сайнцагаан	Махны чиглэлийн үхрийн ферм	Хаан	2015/01/21	38.5	Үлдэгдэлтэй
76	БАЗАР ЦЭРЭНЛХАМ	Сайнцагаан	Оёдлын үйлдвэрлэл	Хаан	2015/08/28	10.0	Үлдэгдэлтэй
77	ЦОГТЫН ШАР МӨРӨН	Сайхан-овоо	Аялал жуулчлал	Хаан	2015/08/28	20.0	Үлдэгдэлтэй
78	ДАНГААЖАВ БАЯСГАЛАН	Сайнцагаан	Хуванцар болон төмөр вакуум цонхны үйлдвэр	Хаан	2015/09/09	20.0	Үлдэгдэлтэй
79	АМЬДРАЛЫН ТУГ	Адаацаг	"Гал голомт " цогцолбор засварлах	Хаан	2015.10.12	10.0	Үлдэгдэлтэй
80	Бадрах БАТНАРАН	Сайнцагаан	Хүлэмжийн ногоо тариалалт	Хас	2015.07.28	15.0	Үлдэгдэлтэй
81	Батаа ОЮУНБИЛЭГ	Сайнцагаан	Оёдлын үйлдвэрлэл	Хас	2015.07.30	10.0	Үлдэгдэлтэй
82	Дамиранжав БАДРАХ	Сайнцагаан	Цэвэр ус	Хас	2015.07.30	20.0	Үлдэгдэлтэй
83	Онгийн хийд ХХК	Сайхан-овоо	Аялал жуулчлал	Хас	2015.07.31	10.0	Асуудалтай
84	Мягмар ШАТАРБААТАР	Сайнцагаан	Хими цэвэрлэгээ	Хас	2015.08.03	20.0	Үлдэгдэлтэй
85	Пүрэвсүрэн МӨНХБАЯР	Сайнцагаан	Төмрийн үйлдвэрлэл	Хас	2015.08.11	15.0	Үлдэгдэлтэй
86	Цэдэнбат ЭНХТУЯА	Сайнцагаан	Талх нарийн боов	Хас	2015.08.12	10.0	Үлдэгдэлтэй
87	ЭРХЭТ ЕМБҮҮ ХХК	Сайнцагаан	Оёдлын үйлдвэрлэл	Хас	2015.08.12	20.0	Үлдэгдэлтэй
88	Мягмарбат ЦЭРЭНПАГМА	Сайнцагаан	Оёдлын үйлдвэрлэл	Хас	2015.08.17	10.0	Үлдэгдэлтэй
89	Батбилэг ХҮРЭЛЧӨДӨР	Сайнцагаан	Хүлэмжийн ногоо тариалалт	Хас	2015.08.18	10.0	Үлдэгдэлтэй
90	Хосгарьд магнар ХХК	Сайнцагаан	Модон эдлэлийн үйлдвэрлэл	Хас	2015.11.05	10.0	Үлдэгдэлтэй
91	Баяраа БАТБОЛД	Сайнцагаан	Мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хадгалалт	Хас	2015.11.06	25.0	Шүүх
92	Батсайхан МЭНДБАЯР	Сайнцагаан	Үнээний ферм	Хас	2015.11.06	20.0	Үлдэгдэлтэй
93	Нямзав Баярсайхан	Сайнцагаан	Алт мөнгөний дархан	Хас	2015.11.18	10.0	Үлдэгдэлтэй
94	Цэвэгжав МАНДАХНАР	Сайнцагаан	Сүү, цагаан идээ	Хас	2016.01.22	10.0	Үлдэгдэлтэй
95	Л.Мөнхтөр	Сайнцагаан	Цайны газар	Хас	2016.01.22	15.0	Үлдэгдэлтэй
						2,747.9	

*Ногоон цэнхэрээр будагдсан зээлдэгч нар аудитад хамрагдсан

ЖДҮС-аас зээл авсан төсөл хэрэгжүүлэгч нарын хэрэгжилт

“Мандал шилтгээн” ХХК нь 2010 оноос барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Дундговь аймгийн Хөдөлмөрийн хэлтсээр /хуучин нэрээр/ дамжуулан 2013 онд 40.0 сая төгрөг, 2014 онд 21.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг тус тус авсан. Байнгын ажлын байр 10 хүн, улирлын чанартай гэрээтээр 5-7 хүн нэмж ажиллуулдаг.

Зээлийн санхүүжилтээрээ үйлдвэрийн газар, бетон хэвлэгч, бетон зуурагч гэх мэт тоног төхөөрөмж худалдан авсан. Өөрийн эзэмшлийн 1 га газарт 11 ажилтантайгаар үйл ажиллагаа хэвийн явуулж байна. Явган хүний замын хавтан, ялу, хашлага, брошур, блок, тоосго гэх мэт бүтээгдэхүүн үйлдвэрлэж барилгын компаниудад нийлүүлж байна. Өдөрт 50 метр куб бетон зуурмаг үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд жилд 250.0 сая төгрөгний борлуулалтын орлоготой ажилладаг. Цаашид барилга угсралтын чиглэлээр үйл ажиллагаагаа өргөтгөхөөр төлөвлөн ажиллаж байна.



1. “Буянт чандмань” ХХК Барилгын дээврийн төмөр хийдэг /Өргөтгөх/
2013 онд 30.0 сая төгрөгийн зээл авсан



2. Д.Нарандэлгэр “Үнээний ферм” /Шинээр эхэлсэн/
2014 онд 30.0 сая төгрөгийн зээл авсан



3. Б.Цэрэнлхам Оёдлын үйлдвэрлэл /Өргөтгөх/ 2015 он 10.0 сая төгрөг
Бөс барааны дэлгүүртээ монгол дээлний захиалга авч гэртээ хүүхдээ хардаг
ээжүүдээр гэрээгээр шат дамжлагатайгаар дээл оёулдаг. /Түр ажлын байр 10-15/



4. Л.Мөнхбаяр Цайны газар, хөлдөөсөн бууз, банш /2016 он 15.0 сая төгрөг/
Наран зоогийн газрын засвар болон тоног төхөөрөмж

